

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 14/393

НШУС

2013

ХЭЛНИЙ ДАРХЛААГ ХАМГААЛАХАД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ҮҮРЭГ

Н.Ариунзаяа*

* «Отгонтэнгэр» их сургууль, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор

Түлхүүр үг: даяаршил, хэлний бодлого, хэлний дархлаа, харь хэл, төрөлх хэл, үгийн утга, сул үг, илтгэгч дүрэм, нэршил

Cүүлийн үед төрөлх хэл ядуурч байгаад эрдэмтэн мэргэд төдийгүй энгийн иргэд ч санаа зовох болжээ. Монгол хэл мөхлийн ирмэг дээр ирлээ гэж үздэг нэгэн ч байна. Миний бodoход мөхөх тухай ярих нь арай хэтийдсэн ойлголт байх. Харин ядуурч байгаа нь зайлбаргүй үнэн. Өөрийн гэсэн бичиг үсэгтэй, бүх нийтээрээ ярьж харилцдаг, системтэйгээр зааж сургадаг хэлийг “амьд” хэл гэдэг. Энэ шалгугаар цэгнэж үзвэл монгол хэл амьд хэл бөгөөд мөхлийн тухай ярих нь эртэдсэн хэрэг юм. Гэвч энэ нь тайвшрах шалтгаан биш билээ. Даяаршлын өнөө үед бага улс үндэстнүүдийн хэл харь хэлний нөлөөнд автаж, улмаар уусах аюул улам бүр нэмэгдэж байна. Өнөөгийн байдлаар дэлхий дээр 6912 хэл бий гэдэг. Тэдгээрийн 6712 хэлээр нь дэлхийн хүн амын ердөө 6,0 хувь нь ярьдаг байна. Гэтэл хүн төрөлхтний 94,0 хувь нь ердөө 242 хэлээр ярьдаг гэсэн судалгааг АНУ-ын Хэл

шинжлэлийн хүрээлэн гаргасан байдаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс үндэстний хэлийг хамгаалах асуудал нэг улс үндэстний хүрээнээс аль хэдийнэ хальж хүн төрөлхтний сэтгэл зовоосон асуудал болсон нь тодорхой билээ. Түүний дотор НҮБ-ын төрөлжсөн байгууллага — ЮНЕСКО «Соёлын олон төрлийг хамгаалах аргаар үндэстнийг аврах»¹ бодлогын хүрээнд дэлхийн бага үндэстнүүдийн хэлийг хамгаалах ажил зохиож эхэлсэн билээ. Үүний тодорхой жишээ нь НҮБ 2008 оныг дэлхийн олон улсын эх хэлний жил болгон зарлаж, ЮНЕСКО «Хэлний хамтлаг бүхэн өөрийн эх хэлийг аль болохоор өргөн, байнга, түүний дотор боловсролын салбарт ашиглахад чиглэсэн хэлний бодлогыг хөгжүүлэх» уриалга гаргасан явдал мөн.

Манай орны хэл шинжлэлийн мэргэжилтнүүд ч эх хэлээ цэвэр ариун байлгах, харь хэлний нөлөө, хазгай буруу хэрэглээнээс болж хэлний дархлаа супрах эндэгдлээс хамгаалах арга боломжийг судлан хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай хэрэг. Эрдэмтэн мэргэдийн үзэж байгаагаар хэлний дархлаа супрах олон шалтгаан байгаагийн дотор бид бүхэн өдөр

Тутмын аман болон бичгийн харилцаандаа төрөлх хэлээ аль хэр зөв, соёлтой хэрэглэж байгаагаас ихээхэн шалтгаалдаг байна. Өөрөөр хэлбэл бид төрөлх хэлээ хайш яиш, хазгай буруу хэрэглэдэг нь хэлийг ядууруулах нэг шалтгаан аж. Түүнийгээ хэв ёс мэт ойлгож өөрсдийгөө буруу ярьж, зөв ойлгодог ард түмэн гэж сайрхах өнгө аястай үг ч цухалзаж байдаг.

Төрөлх хэлний дархлааг хамгаалахад ХМХ онцгой үүрэг хүлээдэг. Өнөөгийн ХМХ, тэдгээрийн сэтгүүлч, уран бүтээлчид энэ үүргээ төдийлөн хэрэгжүүлж чадахгүй байна. Ялангуяа телевиз, сонин хоёр бол монгол хэлийг ядууруулагч гол эзэд гэж үзэх явдал нийгмийн дунд түгээмэл болсон нь үнэний хувьтай билээ. Манай өвөг дээдэс “Үгэн дотор утга, үхэр дотор тугал” гэлцдэг. Энэ нь үгээ бодож, утгад нь нийцүүлж ярихыг сургасан үг юм. Шинжлэх ухааны үүднээс авч үзвэл хэл бол сэтгэлгээний үргэлжлэл, илрэн гарах хэлбэр нь юм. Тэгэхээр бодлогогүй, эмх замбараагүй ярьж, бичдэг хүн бол эмх замбараагүй сэтгэдэг хүн болж таарна.

Телевизийн сэтгүүлчдийн хэл ярианы соёл, эмх цэгц тун хангалтгүй байгааг олон жишээгээр баталж болно. “Дуучин Жавхлангийн зүгээс зориулж байна”, “Засгийн газрын зүгээс үнийг тогтвортой барина” гэх мэт үг хэллэгийг телевизийн сэтгүүлч, хөтлөгчид дэлгэрүүлсэн. Ийм хэллэгийг зөв найруулж бичих дүрмийн үүднээс шинжилж үзвэл үйлийн эзэнгүй хоосон үг болж байна. “Барих”, “зориулах” гэсэн хоёр үйл үг “Хэн?” гэсэн асуултаар үйлийн эзнийг нэхдэг. Гэтэл энэ хоёр өгүүлбэрт “баръж”, “зориулж” байгаа эзэн нь алга. Жавхлан, Засгийн газар хоёр “барих”,

“зариулах” үйлийн эзэн болж чадахгүй учир нь тэдний “зүгээс” юу нь ч мэдэгдэхгүй нэг юм (бодвол хэн нэг хүн байх) зориулсан гээд байгаа биз дээ. Ингэж хэл яриаг зэрэмдэглэх зурсшил газар авсан. Телевизийн хөтлөгчид (голдуу бусгүйчүүд байдаг) бараг бүгдээрээ “Бидний урилгыг хүлээн авч ярилцсанд баярлалаа гэж хэлье” гэх юм. “Хэлье” гэдэг үг цаанаасаа нэг хөндий хүйтэн, ёс төдий сонсогдох байгаа төдийгүй ерөөсөө баярлаагүй зүгээр л баярлалаа гэж хэлж байгаа юм шүү гэсэнтэй адил юм. Үүнээс долоон дор үг хэллэг ч байна. Тэр нь “Баярлалаа гэж хэлмээр байна” гэдэг үг. Өмнөх нь ёс төдий баялалаа гэж хэлсэн бол, энэ удаад “хэлмээр байна, гэвч хэлэхгүй” гэсэн шиг утга гарч байна. Энэ нь хүүхдэд нэг чихэр үзүүлээд “өгмөөр л байна, гэвч яршиг даа” гээд далд хийсэнтэй адил юм. Зочиндоо “Баярлалаа” гэдэг үгийг сэтгэлээсээ шуудхан хэлчихэж чадахгүй хэльюу, байюу гээд үгээ идэж суудаг сэтгүүлч, хөтлөгчдийг хэл ярианы соёлтой гэхэд бэрх.

Үлс төрчдийн албархаж хэлснийг сэтгүүлчид өлгийдэж аваад хэвшүүлчихсэн бас нэг бүлэг буруу үг хэллэг аялгуу сайхан монгол хэлийг мэрэн идсээр байна. Сонгодог жишээ нь “арга хэмжээ”, “энэ утгаараа” гэдэг үгс. Төрийн түшээ телевизийн сурвалжлагчтай ярилцаж байгаад “Би дараа нь бас нэг арга хэмжээтэй” гээд өндөлзэж байх юм. Эхлээд үгийнхээс утгыг бодьё. “Арга хэмжээ” гэдэг үг шийтгэл, зэмлэл гэсэн утгатай. Хариуцлага алдсан албан тушаалтанд торгох, донгodoх, тушаал бууруулах, цалин бууруулах, сануулах зэрэг арга хэмжээ авдаг. Тэгэхээр эрхэм төрийн түшээ-

гийн хэлж байгаа үгийг удахгүй нэг газарт очиж шийтгэл хүлээх юм байна гэж ойлгомоор. Гэтэл “бас нэг” гэдэг үг хэрэглэснээрээ яг энэ мөчид сэтгүүлчтэй ярилцаж байгаагаа ч “арга хэмжээ” гэж үзэж байгаа бололтой. Аливаа хурал цуглаан, үдэшлэг уулзалт зохион байгуулах, барилгын суурь тавих, ашиглалтад хүлээн авах, сургуулийн хичээлийн шинэ жилийг нээх, спорт, урлагийн тоглолтод байлцах зэргийг өнөө үед “арга хэмжээ” гэж нэрлэдэг болжээ. Өнгөц бodoход анзарагдахгүй боловч ингэж ярьж, бичих нь ихээхэн хортой юм. “Арга хэмжээ” гэдэг үгийг ажил хэрэг, сайн сайхан үйлийн нэр болгочихож болдог юм байж гэж бодъё. Тэгвэл шийтлэл зэмлэл хүлээсэн хүнийг гавьяа байгуулсан гэдэг утгаар ойлгох уу?

Монгол хэлний үг олон утгатай байх нь түгээмэл юм. Гэтэл үгийн тэрхүү олон салаа утгаас нэгийг нь өлгөж аваад өөрийн үзэл бодлыг зөвтгөх гэж дөргүй бух шиг зүтгэдэг улс төрчид “эн утгаараа” гэдэг үгийг өргөн хэрэглэх болсон юм. Одоо энэ үг хүн бүхэнд халдвартажээ.

Сэтгүүлчдийн сул үг, болхи яриа нийгэмд нэг хэсэгтээ этгээд содон сонсогдож байснаа, аажимдаа нүд чихэнд дасал болж анзарагдахаа больдог байна. Манай сэтгүүлчдийн ярианд хог өвс мэт яргасан “одоо”, “за” хоёрыг ийм үгийн жишээнд нэрлэж болно. Өгүүлбэр болгоноо “за”-гаар эхэлдэггүй, гурван үг тутамд “одоо”-г хэрэглэдэггүй сэтгүүлч өдрийн од шиг болжээ. Энэ нь нэгд: сул үг олдсоноос болж цаг үрдэг, хоёрт: ярианы эрчийг сааруулж, утгыг супруулдаг, гуравт: илтгэгчийн бэлтгэл муу, сэдвээ зээмшээгүйн шинж болдог,

дөрөвт: олон нийтэд сул үг хэрэглэх муу үлгэр үзүүлдэг зэрэг сөрөг талтай юм.

Нийгмийн шилжилтийн үед соёлын салбарт гарсан хямралт үзэгдлийн нэг нь хэлний засаглалын хомсдол байсан. Бүх нийтээрээ худам монгол бичиг сурах хөдөлгөөн өrnөхийн зэрэгцээгээр монгол бичгийг төрийн албан ёсны бичиг үсэг болгох, улмаар кирил монгол бичгийг халах тухай яриа дэлгэрч эхэлсэн нь өнөөгийн албан ёсны хэлбичиг — кирил бичигт тавих анхаарлыг супруулсан юм. Энэ нь олон жил журамлаж ирсэн кирил бичгийн дүрмийг мөрдөхгүй байх, дур зоргоороо өөрчлөх, монгол бичгийн дүрмээр бичихийг оролдох зэргээр илэрч, улмаар замбараагүй хэрэглээнд хүргэсэн билээ. Нэр томьёоны хувьд ч ихээхэн цалгайдал гарсан юм. Ерээд оны үеэс төр, засгийн төв байгууллага, яам тамгын газрын нэрийг өөрчилсөн нь цаг үеийнхээ агуулгад нийцсэн шийдвэр байсан ч ихээхэн алдаа дагуулсан. Ардын Их Хурлыг Улсын Их Хурал, Сайд нарын Зөвлөлийг Засгийн газар, Сайд нарын Зөвлөлийн даргыг Ерөнхий сайд, орлогч даргыг шадар сайд гэх мэтээр сольсон нь зохимжтой нэршил болсон. Гэтэл “Байгаль орчны сайд”, “Эрүүл мэндийн сайд” гэх мэт зохимжгүй үгс гараад ирсэн нь анхандаа этгээд, инээдэмтэй сонсогдож байсан билээ. “Сайд” гэдэг үг хэзээнээсээ “төр”, “яам” гэдэг хоёр үйтэй холбогдож иржээ. Сайд хүн (тэр тусмаа салбарын) заавал нэг яамыг толгойлж байдаг. Дээр үед хамжлагагүй тайжийг “хохь тайж” гэдэг байсан шиг яамгүй сайдыг “Төрийн сайд”, “Монгол улсын сайд” гэх мэтээр ялгамжлан нэрлэж байгаа нь сайд хүн

Засгийн газар, эсвэл аль нэг яамных байдгийг харуулж байгаа хэрэг. Гэтэл ТҮҮНЭС нь салгаад “Байгаль орчны сайд” гэх нь “байгал хамгаалагч”, эсвэл “оин цагдаа” гэсэнтэй адил сонсогдоод байдаг. Нөгөө талаар төрийн яамыг удирдан чиглүүлж, бодлого боловсруулдаг чиг үүргийг нь бүрхэгдүүлж, орь ганцаараа уул ус, ой модоо хараад тэнэж явдаг хүн мэт ойлголт төрүүлдэг.

“Эрүүл мэндийн сайд” гэдэг уг ч мөн ялгаагүй. Яам хэмээх бүтэцгүйгээр, түүний эрэг шураг болсон газар, хэлтэс, тасаг, тэдгээрийн дарга удирдагчгүйгээр сайд юу хийж чадах билээ. Ингээд бодохоор “Эрүүл мэндийн сайд” биш, “Эрүүл мэндийн яамны сайд” байх нь зөв юм. Энэ буруу нэршил төрийн үйлчилгээний зарим байгууллага, тухайлбал их, дээд сургуулийн нэрэнд ч нөлөөлсөн юм. “Боловсролын Их Сургууль”, “Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль”, “Хууль Сахиулахын Их Сургууль” гэх болж. Эдгээр нэршил бүгд оновчгүй, зарим нь огт буруу байна. “Боловсрол” гэдэг маш өргөн ойлголт юм. Боловсролыг сургуультай сургуульгүй, системтэй системгүй, албан ба албан бус, хаана ч, ямар ч хэлбэрээр эзэмшиж болно. Эцсийн эцэст хүнийг хөгжүүлэхэд хэрэгтэй бүхэн боловсрол юм. Өөр бодомж гаргаж үзье. Боловсролын Их Сургууль бүх нийтэд боловсрол олгодог газар мөн үү? Биш ээ. Харин боловсрол

олгоход чухал үүрэгтэй төрөл бурийн мэргэжлийн багш нарыг бэлтгэдэг сургууль юм. Дахиад нэг учир хэлэхэд ерөөсөө боловсрол олгодоггүй сургууль гэж байхгүй шүү дээ. Ингээд бодохоор “Багшийн Их Сургууль” гэдэг нь агуулгадаа нийцсэн зөв нэршил болно. “Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль” гэх юм. Эрүүл мэндийн шинжлэх ухаан гэх нь дэндүү ерөнхий, оновчгүй бас юм.

Эрүүл мэнд байж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд олон хүчин зүйл нөлөөлдгийг бодсон ч энэ нэр зохимжгүй. Нөгөө талаар “эрүүл мэнд” гэдэг уг шинжлэх ухааны нэр томьёо гэ. хээсээ амьдрал ахуйн хүрээнд

Төрөлх хэлний дархлааг хамгаалахад ХМХ онцгой үүрэг хүлээдэг. Өнөөгийн ХМХ, тэдгээрийн сэтгүүлч, уран бүтээлчид эн үүргээ тодийлон хэрэгжүүлж чадахгүй байна. Ялангуяа телевиз, сонин хоёр бол монгол хэлийг ядууруулагч гол эзэд гэж үзэх явдал нийгмийн дунд түгээмэл болсон нь үзүүлэх хувьтай билээ.

»

хэрэглэгддэг энгийн харилцааны уг юм. “Анагаах ухаан” гэж эргэлзэх юмгүй сайхан нэр байсаар байтал ингэж солихын тулд сольдог нь хачирхалтай. “Шинжлэх ухаан”-ы Их Сургууль гэдэг нь бүр ч оновчгүй болсон. Тэгэж яривал бусад сургууль шинжлэх ухаан заадаггүй болж таарах уу гэсэн асуулт гарахыг бодолцох ёстой байсан.

Ойрмогхон хүчний байгууллагын мэргэжилтэн бэлтгэдэг хэдэн сургуулийг нэгтгээд “Хууль Сахиулахын Их Сургууль” гэх болсон нь бас л хуудуутай нэр болсон. “Их Сургууль” гэдгийг нь аваад хаячихвал зүгээр л нэг дамжааны нэр шиг сонсогдоно. Хууль цаазын ухаан (сүүлийн үед хууль зүйн гэх болсон) гэж уламжлалт

шинжлэх ухаан байдгийг хэн бүхэн мэддэг. Харин хууль сахиулах ухаан, түүнийг зааж сургадаг сургууль байна гэхэд эргэлзээтэй санагдана. Хууль зүйн шинжлэх ухаанд суралцаж байж л хууль сахиулах байгууллагын ажилтан болно. Тэгэхээр хууль сахиулах гэдэг нь шинжлэх ухаан биш, харин хууль зүйн ухааныг эзэмшсэний дараа хийх үйл ажиллагааны нэр болж таарч байна. Цагдаагийн дээд сургууль, Хилийн цэргийн дээд сургууль гэхэд цагдаагийн болон хилийн цэргийн мэргэжилтэн бэлтгэдэг сургууль гэдэг нь хэн бүхэнд тодорхой байсан. Тэдгээрийн дэргэд "Хууль Сахиулахын Их Сургууль" гэдэг нь өмнөхөөсөө долоо дордсон нэр юм. Хуулийг дан ганц хүчний байгууллагынхан биш, төрийн захиргааны бүх байгууллага, тэдгээрийн ажилтнууд, тэр ч байтугай ухамсартай иргэд хүртэл нэгэн адил сахиулдаг гэж бодвол дээрх нэр тохиромжгүй нь улам тодорхой болно. Хэлний мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлчид энэ мэт буруу нэршил гарч ирэх бүрд соргогоор тусгаж шүүмжлэлтэй хандан, засч запруулах, зөв хэвшүүлэхэд дуу хоолойгоо нэгтгэх ажил ихээхэн угүйлэгдэж байна. Мянганы эх нэг гэдэг шиг нэг үг буруу хэвшвэл мянган буруу угний эхлэл болно.

Зарим судлаачийн үзэж байгааар мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэгт гарч байгаа найруулгын алдаанд «Этгээд марзан үг хэллэгийг зохистой хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн, төрөлх хэлний мэдлэг дутмагаас үүдсэн» алдаа зонхицж байгаа аж. Сонины сэтгүүлчийн бичиж найруулах чадвар телевизийнхнээс илүү байдаг нь

мэдээллийг дан ганц үгээр илэрхийлдэгтэй нь холбоотой юм. Харин тэд санаагаа илүү хурц, хүчтэй үгээр гаргах эрмэлзэлдээ хөтлөгдөн хэт бүдүүлэг, увайгүй үгсийг хэрэглэдгээс найруулгын хэм хэмжээ зөрчигдөх нь элбэг үзэгддэг. «Бодоо лам Чойбалсанг багад нь бандидаж, дур хүслээ хангах хэрэгсэл, нууц амрагаа болгож байжээ», «Жингэртэй явалдсан найз», «11 удаа хутгалуулж тамлуулсан эр ус уух тавилантай тулдаа амьд үлджээ» гэх мэт гарчигтай бичлэгийг сонины хуудаснаас хялбархан олж болно.

Телевизийн сэтгүүлчид дурс, дуу чимээ, үйл хөдлөлийг өргөн ашиглаагдтаа найдаж бичвэр ба үг ярианд бага анхаардаг нь найруулгын алдаа гарахад нөлөөлдөг байна. Шуудхан хэлэхэд монгол хэлээ тааруухан мэддэг залуу сэтгүүлч телевизэд олон байна. Жишиэ нь «УИХ-ын 67 дугаар тойргийн сурагчид хөлдөх нь ээ» (TV-9 телевиз, "Энэ өдөр"), «Өвлийн олимпийн анхны тогтолт 1932 онд АНУ-ын 4000 гаруй жижигхэн хүн амтай хотод болжээ» (TV-5 телевиз), «Фтор, кальц агуулсан шүдийг гаднын нөлөөгөөр бохирдохоос хамгаалах PS oo» (TV-9 телевиз, реклам) гэх мэтээр бичиж, ярьж байна. Эхний өгүүлбэрт үг дутсаанаас УИХ-ыг тойротой болгоод зогсоогүй бас сурагчдыг тэрхүү тойротг хамааруулжээ. Тойрог нь УИХ-ынх биш сонгуулийнх, сурагчид нь тойргийнх биш сургуулийнх байх учиртайг бодолцсонгуй. Хоёр дахь өгүүлбэр өвлийн олимп 4000 гаруй жижигхэн (одой) хүнтэй хотод болсон мэтээр ойлгогдож байгаа бол, сүүлчийн өгүүлбэр нь фтор, кальц агуулсан шүд байдаг юм шиг сонсогдож байна. Зүй нь «Өвлийн олимпийн анхны тогтолт

1932 онд АНУ-ын 4000 гаруй хүн амтай жижигхэн хотод болжээ», «Шүдийг гаднын нөлөөгөөр бохирдохоос хамгаалах фтор, кальц агуулсан PS oo» гэх байж. Дээрх хоёр өгүүлбэрт үгийн байр солигдсоноос болж найруулгын алдаа гарсан байна.

Түүнчилэн «Өчигдөр нээлтээ хийж, маргааш аваргаа тодруулах юм байна» (MYONT, спортын мэдээ), «Наян настай Куба улсын тэргүүн Фидель Кастро» (SBN телевиз, "SBN news"), «Тэгвэл энэ үйлс удалгүй ажил болж, хэрэгжиж, эхлэл нь тавигдах нээ» (TV-9 телевиз, "Энэ өдөр"), «Тэрээр өнгөрсөн 7 дугаар сард мэс хагалбарын ажилд орсон» (SBN телевиз, "SBN news"), «3000 Курдын босогч нуугдаж байна» (С-1 телевиз, "Фокус") гэх мэтээр ярьж, бичиж байна. Энэ мэт алдаатай өгүүлбэрүүдийг "Наян нас" Куба улсад биш, Фидель Кастрод хамаарна, аливаа юмны эхлэл нь тавигдсаны дараа ажил болж, хэрэгждэг, мэс ажилбар хийлгэсэн хүнийг өөрөө мэс засал хийдэг ажилд орсон мэт болгосон, «3000 Курд улс энэ дэлхий дээр байхгүй, харин Курд улсын 3000 босогч нуугдсан байж болно гэх мэтээр тайлбарлах гэвэл хэдэн арван боть болохоор байна.

Хэлний дархлааг сулруулж байгаа бас нэг зүйл бол гадаад үгийг хэрэгцээгүй газарт чамирхан хэрэглэх явдал юм. Сонин хэвлэлийн хуудсанд гадаад үг байтугай тийм үгээр бичигдсэн бүхэл бүтэн өгүүлбэр захаас аван тааралдана. Ингэж бичдэг сэтгүүлчид «Нэгэн хоёр иргэн үсэг таниваас даруй монгол үсгээ басамжлан, монгол үсгээр иргэний санааг гаргаж хэрхэн чадмуй хэмээн амны аяар чалчмуу. Энэ нь далайн хөвөөнд

биэз угаагаад далайг гуехэн үзсэнээс өөр юун буй»² гэж агуу их В.Инжин, нашийн хэлж байсныг санаад илүү, дэхгүй.

Төрөлх хэлний дархлааг хамгаалахад төр, засгаас авч хэрэгжүүлж болох ажлын талаар эрдэмтэн мэргэд удаа дараа саналаа илэрхийлж байгаагийн зөвлөл байгуулах, Улсын нэр томъёоны комиссийг дахин сэргээх гэх мэт саналууд байнга гардаг. Ийм байгууллагууд эх хэлний хэрэглээг цэгцтэй, нэг мөр болгоход тустай нь мэдээж юм. Түүнээс дутуугүй бөгөөд дээрээс гарах шийдвэрийг харж суулгүй хэрэгжүүлж болох чухал ажлын нэг нь ХМХ-үүдэд редакторлах уламжлалыг сэргээх явдал болж байна. Үүний тулд редакци бүхэн зөвхөн нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хэл найруулгыг цэгцэлж, зөв бичих дүрмийг мөрдүүлж байх үүрэгтэй нэг нэг утга зохиолын ажилтантай байхад л хангалттай юм.

Mанай ХМХ-үүд нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулгыг сайжруулах арвин туршлага хуримтлуулсан байдаг. Мэдээ матэриалыг гар дамжуулан унших, сайн муу найруулгатай бичлэгийг уран бутзээлч дээр хэлэлцүүлэх, "Улаан харандаа" нэртэй мэдээллийн самбар гаргах, ахуй амьдралд шинээр орж ирж байгаа үгийн мэдээлэл хийх, маргаантай үгийг хэрхэн бичих талаар семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг олон хэлбэрийн ажлыг сэргээх хэрэгтэй байна.

Эцэст тэмдэглэхэд ХМХ-үүд нийгмийг цаг үеийн мэдээллээр хангахын зэрэгцээ эх хэлний хэрэглээг зөв хэвшүүлэх үүргээ ухамсарлах шаардлагатай болжээ.

Ишлэл

¹ 2008. Даяаршил-хэлний бодлого-олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. УБ., 50 дахь тал.

² Инжиннаши В. Хөх судар. I дэвтэр. 60-61 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Буяннэмэх С. 1968. Яруу найруулга. «Түүвэр зохиол». УБ.
2. Норовсүрэн Л. 2007. Хянан найруулах ухаан. УБ.
3. Отгонсүрэн Д. 1995. Эх зохиох товч гарын авлага. УБ.
4. Сүхбаатар Ц. 1988. Орчин цагийн монгол хэлний найруулга зүй. УБ.
5. Хасбаатар Ц. 1986. Хянан найруулах эрдэм. УБ.
6. Виноградов В.В. 1963. Стилистика. «Теория поэтической речи». М.

7. Вовчок П. А. 1978. Сборник упражнений по практической стилистике. Свердловск.

8. Пронин Е. П. 1981. Текстовые факторы эффективности журналистского воздействия. М.

9. Федин К. А. 1971. Писатель, искусство, время. М.

Summary

The article indicates that there's a threat that languages of underdeveloped countries or nations are about to decline or vanish in the globalization era and indicates about role of media in protecting Mongolian language from impact of foreign languages and accustoming to use it correctly and completely. Also it suggested an idea in mother language policy.